



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 01 сарын 23 өдөр

Дугаар А/04

Хэрлэн сум

**Хувцас хэрэгсэлд  
хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Цэргийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.8, Засгийн газрын 2016 оны 215 дугаар тогтоолоор батлагдсан “Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний тоо бүртгэл хөтлөх, мөнгөн төлбөрийг төлөх, хураан авах, төлбөрийн орлогыг ашиглах журам”-ын 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Цэргийн штабын албан үүргээ биелүүлэх нөхцөлийг сайжруулах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, цэргийн дүйцүүлэх алба хаагчдын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны хувцас хэрэгслээр хангах зорилгоор 25,000,000 (хорин таван сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Зарцуулах хөрөнгийг хавсралтаар баталсугай.

3.Дээр үйл ажиллагааны зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын цэргийн бүртгэл сургууль, цугларалт, зориулалтын бараа үйлчилгээний бусад зардлаас гаргахыг Нягтлан бодогч (Х.Баярбаатар)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ж.ГАНТУЛГА

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын  
2024 оны ..... дүгээр сарын ..... ны өдрийн  
..... дугаар тушаалын хавсралт

Цэргийн дүйцүүлэх албаны  
мөнгөн төлбөрийн орлогын зарцуулалтын төсөв

| №    | Үйл ажиллагаа   | Тоо хэмжээ | Мөнгөн дүн (төгрөг) | Хянасан |
|------|---|------------|---------------------|---------|
| 1    | Цэргийн штабын нууцын өрөөг зааврын дагуу засварлаж, тохижуулах   | 1          | 3000000             |         |
| 2    | Цэргийн штабын даргын албан өрөөг засварлах   | 1          | 3500000             |         |
| 3    | Цэргийн штабын эзэмшлийн авто машины засвар үйлчилгээ   | 1          | 5000000             |         |
| 4    | Батлах хамгаалах үйл ажиллагааг орон нутагт хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай ажилласан иргэд албан тушаалтныг урамшуулах | 5          | 2500000             |         |
| 5    | Цэргийн дүйцүүлэх алба хааж байгаа иргэдийг хөдөлмөр хамгааллын өвлийн хувцас худалдан авах                               | 20         | 6000000             |         |
| 6    | Цэргийн дүйцүүлэх алба хааж байгаа иргэдийн албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай аранз худалдан авах                     | 20         | 5000000             |         |
| Нийт |   |            | 25000000            |         |